

# “ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр

№ТУЗТ 04/2022

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Нийтэд санал болгох энгийн хувьцааны  
тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.10.12 дах хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2 болон 3-дах заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01-р сарын 31-ний өдрийн №ТУЗТ 02/2022 тоот тогтоолын 1 болон 2 дах заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2-т заасан “Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг хүртэлх энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 6.00 (зургаа) хувьтай тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай.” гэснийг “Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 16,572,469 (арван зургаан сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун жаран ес) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай.” гэж өөрчилсүгэй.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 01/2021 тоот тогтоолын 3-т заасан “Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 5,536,868 (таван сая таван зуун гучин зургаан мянга найман зуун жаран найм) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргахаар тогтоосугай.” гэснийг “Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 (арван зургаан сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун жаран ес) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 1,949,129 (нэг сая есөн зуун дөчин есөн мянга нэг зуун хорин ес) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргасугай.” гэж өөрчилсүгэй.
3. Компанийн Дүрмийн төслийг 1-р хавсралтаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/